

## “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2018 оны 4-р сарын 29-ний өдөр

Дархан-Уул аймаг, Дархан сум

“Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4-р сарын 29-ний өдрийн 13.00 цагт Дархан-Уул аймаг, Дархан сумын 1-р баг, “Дархан гурил тэжээл” ХК-ийн гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хурлын даргаар томилогдсон Ш.Энхтөр хурлыг удирдан явуулав.

Хурлын дарга Ш.Энхтөр тооллогын комиссын бүрэлдхүүн Д.Уртнасан, М.Өлзийсүрэн, Б.Нямдэлгэр нарыг танилцуулж, тооллогын комиссыг хурлын ирцийн талаар мэдээлэл хийхийг хүслээ.

Д.Уртнасан: Хуралд нийт 614603 хувьцаа эзэмшигчдээс 551287 ширхэг хувьцааг эзэмшигчид буюу нийт хувьцааны 90%-ийг эзэмшигчид ирсэн.

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн тухай хууль болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.5.21-д зааснаар ирц хүчин төгөлдөр тул хурлыг хуралдуулахаар шийдвэрлэв.

Хурлын дарга Ш.Энхтөр: Ээлжит хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах 15 мин
2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт 15 мин
3. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, шинээр сонгох 15 мин
4. Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх цаг тогтоохгүй

Оролцогчдын 100% саналаар хэлэлцэх асуудлыг батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хурлын дэгийг уншиж танилцуулав. /дэг хавсаргасан/

Хурлын дэгийг 100% санал нэгтэй батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцэх асуудалдаа оръё. “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах” асуудал байгаа, гүйцэтгэх захирал С.Намсрайжав танилцуулна.

С.Намсрайжав: Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хавсаргалаа. Эргэлтийн хөрөнгийн дутагдалтай байдлаас түүхий эд худалдан авч чадаагүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа үндсэндээ явуулаагүй. Дотоодын

арилжааны банкны эргэлтийн хөрөнгийн зээлийн нөхцөл их хүнд: хугацаа богино, хүү өндөр байгаа нь зах зээлд өөрийн байр сууриа гүйцэд эзэлж чадаагүй, борлуулалт жигдрээгүй бидний хувьд дийлэхгүй ачаа болоод байна. Урт хугацаатай, хүү багатай харьцангуй нөхцөл сайтай зээл хөөцөлдөөд бараг 1 жилийн нүүр үзэж байгаа. Цаашдаа гурилаа боловсруулж эцсийн бүтээгдхүүн, экспортын бүтээгдхүүн үйлдвэрлэх зайлшгүй шаардлага гарч холбогдох тооцоо, зах зээлийн судалгаа, тоног төхөөрөмж, технологийн судалгаа хийж байна. Энэ жил хөндлөнгийн аудитаар "Юнистар-аудит" ХХК ажиллалаа. Маш их судалгаа хийж, үнэтэй зөвлөмж өгсөн. Аудитын дүгнэлтийг хавсаргалаа. Хагас жилийн санхүүгийн тайланд задгай байгаа өглөг авлагын тооцоог нэгтгэх, хөрөнгийн бүртгэлийн үнэлгээ хийлгэж зөв тусгах зөвлөмж авсан, мэргэжлийн зөвлөгөө өгнө гэсэн. Юуны өмнө үйлдвэрлэлийн тооцоог хийдэг санхүүгийн программ худалдан авч бүртгэлдээ ашиглахаас ажлын сайжруулалтаа эхэлнэ. Компанийн дүрмийн сангийн өөрчлөлтийг засч Улсын бүртгэлийн байгууллагад зөвөөр бүртгүүлнэ, энэ талаар шийдвэр гаргаж өгөхийг хүсч байна.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн түүхий эд худалдан авах эргэлтийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тал дээр анхаарч өгнө үү. Үйлдвэр ажиллуулах эргэлтийн хөрөнгө, намрын ургацаас авах улаанбуудай тариаланчдад өгөх урьдчилгаа гээд хөрөнгийн хэрэгцээ улам их шаардагдаж байна.

Хурлын дарга Ш.Энхтөр: Эргэлтийн хөрөнгийн асуудлыг бүгд мэдэж байгаа, дор бүрнээ л ажиллаж байна. Ямар ямар хүндрэл гараад байгааг ч бид мэдэж байгаа. Асуудлыг нэг нэгээр нь шийдээд л тэмцэж байгаа, цаашдаа ч ажиллаад үр дүн гаргана, өөр гарц байхгүйг ч бид мэдээд ярилцаад ажиллаж байна.

Хурлын дарга Ш.Энхтөр: Энэ асуудлаар өөр хэнд асуулт, тодруулга байна вэ?

Асуулт гарсангүй.

Хурлын дарга Ш.Энхтөр: Нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа, өөр асуулт алга. Хэлэлцсэн асуудлыг дүгнэж хурлын тогтоолын төслүүдийг танилцууллаа.

Хуралд оролцогсод 100%-ийн саналаар батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцэж буй асуудлаар гарах шийдвэрийг дор бүр нь танилцуулаад санал гаргаад явъя, төгсгөлд нь санал авах хуудсаар давхар баталгаажуулна гэлээ.

Хурлын дарга Ш.Энхтөр: Дараагийн асуудалдаа оръё. Гүйцэтгэх захирал С.Намсрайжав саналаа танилцуулна.

С.Намсрайжав: Гаднын хөрөнгө оруулагчид болон банкны хүмүүстэй гүйцэтгэх захирал харилцаа үүсгэдэг. Та шийдвэр гаргагч мөн үү гэх мэтийн асуултанд

хариулт өгөх шаардлага гардаг. Нэгэнт бидний нэгдмэл сонирхолтой этгээдүүд 90% хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд ерөнхий захиралтай байж болох уу, болдог бол компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж болох уу?

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн тухай хуулиар хувьцаат компанийн удирдлага гүйцэтгэх захирал гэж заасан. Компанийн хэлбэрийг өөрчлөхөөс өөр боломжгүй ээ. Иймд компанийн дүрмэнд өөрчлөлт оруулах боломжгүй.

Хурлын дарга Ш.Энхтөр: Энэ асуудлаар өөр асуулт байна уу?

Асуулт гарсангүй.

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг татгалзлаа. Саналаа хураая, 100% дүрэмд өөрчлөлт оруулахгүй гэлээ.

Хурлын дарга Ш.Энхтөр: ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох асуудлыг хэлэлцье.

С.Намсрайжав: Иргэн Э.Содгэрэл компанийн хувьцаа эзэмшигч биш болсон, ТУЗ-ийн гишүүнээс татгалзсан, иймд ТУЗ-д Б.Түвшинжаргалыг шинээр оруулах саналтай байна. Түүнчлэн хараат бус гишүүн Л.Цэрэн-Очир чөлөөлүүлэх хүсэлтээ гаргасан, шинээр Пүрэвдаваагийн Мандахнарангийн /П.Мандуул/ нэрийг дэвшүүлж байна. П.Мандахнаран /П.Мандуул/ нь хууль эрх зүйч мэргэжилтэй. Бизнесийн байгууллагад ажилладаг туршлагатай.

Ш.Энхтөр: Нэр дэвшигчдийг оролцуулаад санал хураая.

Ш.Энхтөр: Хуралд хэлэлцсэн асуудлаар саналын хуудас бэлдсэн та бүхэн саналаа өгнө үү.

Ш.Энхтөр: Саналын хуудсаар өгсөн саналыг тоолж дууссан байна, тооллогын комиссын дарга Д.Уртнасан шийдвэрээ танилцуулна уу.

Д.Уртнасан: тооллогын комиссын шийдвэрүүдийг уншиж танилцууллаа.

Ш.Энхтөр: Тооллогын комиссын шийдвэрүүдийг баталгаажуулъя.

Татгалзаж, түдгэлзэж байгаа хүн байна уу? Байхгүй байнаа.

Баталгаажуулах саналтай хүмүүс гараа өргөнө үү.

100%-ийн саналаар тооллогын комиссын шийдвэрүүдийг баталлаа.

Ш.Энхтөр: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрүүдийг уншиж танилцуулъя. Татгалзаж түдгэлзэх хүн байна уу? Байсангүй, шийдвэрүүдийг батлах нь гараа өргөнө үү?

Хурлаас гарах шийдвэрүүдийг 100% саналаар баталгаажууллаа.

Ш.Энхтөр: ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, амжилт хүсье.

Ш.Энхтөр: Дархан гурил тэжээл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хурлын материалаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Улсын бүртгэлийн албанд гаргаж, бүртгүүлэх ажлыг ТУЗ, гүйцэтгэх удирдлагад даалгаж байна. Хуралд оролцсон та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Хурал: 2018 оны 4-р сарын 29-ний 14.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн



Ш.Энхтөр

Р.Болдбаатар